



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/847

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “в”, 29.1.6 “л”, 29.2 Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 12.1.4, 12.1.7, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дах зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. 2017 оны 10 дугаар сард цас ихээр орж, орон нутгийн чанартай авто зам хаагдаж, Цагаанбургасын давааг нээх засварын ажлын зардал 2068200 төгрөгийг “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний дагуу гүйцэтгэгч аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт олгож, зардлыг замын сангийн нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн ерөнхий санхүүч /Ц.Мөнхтуяа/-д зөвшөөрсүгэй.

2. Цаашид Цагаанбургасын даваа хаагдсан нөхцөлд орон нутгийн чанартай замыг нээлттэй байлгах чиг үүргийг аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хариуцуулан ажиллаж, гүйцэтгэлийн зардлыг замын сангийн нөөц хөрөнгөөс санхүүжүүлж, “Зам засварын ажил гүйцэтгэх гэрээ” байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Г.Гандэлгэр/ нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД